



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/36

Булган сум

Төлөвлөгөө батлуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6 дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 онд сумын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Баталсан төлөвлөгөөний дагуу сумын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийж, үр дүнг тайлагнахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ӨРДЭНЭ

